“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 12 өдөр Дугаар А/98 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, “Баганууурын дулааны станц”ТӨХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.11.10 дахь заалт, “Баганууурын дулааны станц”ТӨХК-ийн Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1.“Баганууурын дулааны станц”ТӨХК-ийн дулааны техникийн нөхцөл олгох зөвлөлийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан журмыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийт алба, хэлтэс, хэсгийн удирдлага, инженер техникийн ажилтнуудад, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дотоод аудитор (Н.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.АРИУН-ЭРДЭНЭ

УЛААНБААТАР ХОТ
БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК
2725060005
2688794 Д. ХНТ9684

1226040135

“Багануурын дулааны станц”ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 20.26 оны 06 сарын
12-ны өдрийн А/98-р тушаалын хавсралт

УЛААНБААТАР ХОТ
БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК
2725060005
2688794 А. ХНТ9684

ДУЛААНЫ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Багануур дүүргийн төвлөрсөн дулаан хангамжийн системд шинээр барилга, обьект холбох техникийн нөхцөл олгох үүрэг бүхий “Багануурын дулааны станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/50 дугаар тушаалаар батлагдсан “Дулааны техникийн нөхцөл олгох зөвлөл” (цаашид “зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг хангахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор батлсан “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 1.4 дэх хэсэгт заасны дагуу 1.0 Гкал/ц ачааллаас бага тохиолдолд тухайн орон нутгийн дулаан түгээх тусгай зөвшөөрөлтэй компанийн техникийн нөхцөл олгох ажлын хэсэг, 5.0 Гкал/ц хүртэл ачааллыг дулааны шугам сүлжээний горим ажиллагаанд нөлөөлөх, техник технологийн шинэчлэл хийх тухай бүр Эрчим хүчний яам (техникийн нөхцөл олгох ажлын хэсэг)-тэй хамтран гаргах, 5.0Гкал/ц-аас дээш ачааллыг Эрчим хүчний яам (техникийн нөхцөл олгох ажлын хэсэг)-ны хурлаар тус тус шийдвэрлэж олгоно.

1.3.Иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжийн зураг, төсөл боловсруулах, зураг төслийн ажлын гүйцэтгэл, барилга угсралтын ажилд хяналт тавих, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авахад энэ журмаар олгогдсон техникийн нөхцөлийг мөрдлөг болгоно.

Хоёр. Техникийн нөхцөл олголт

2.1.Аливаа иргэн болон хуулийн этгээдэд дулааны техникийн нөхцөл олгохдоо Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор батлсан “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”, Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 290 дүгээр тогтоолоор батлсан “Дулаан дамжуулах, түгээх сүлжээний холболтын журам”, Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/33 дугаар тушаалын хавсралт болох “Техникийн нөхцөлийн хүсэлтийг цахим системээр шийдвэрлэх ажлын хэсгийн ажиллах журам”, тус компанийн энэхүү журмыг тус тус үндэслэнэ.

2.2. Иргэн, хуулийн этгээд нь төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдсон халаалтын систем бүхий шинээр барилга, объект барих, хуучин барилга объектоо нурааж шинэчлэн өргөтгөх, ачааллыг өөрчлөх болон дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээ, халаалтын системийн техникийн шийдлийг өөрчлөх технологийн шинэчлэл хийх нь тухай бүр шинээр техникийн нөхцөл гаргуулах үндэслэл болно.

2.3. Техникийн нөхцөл хүсэж буй иргэн, хуулийн этгээд нь дараах баримт бичиг, материалыг бүрэн хэмжээнд бүрдүүлж цахим системд оруулсан байна. Үүнд:

- Архитектур төлөвлөлтийн даалгавар (Улаанбаатар хотын Ерөнхий архитекторын батласан)
- Батлагдсан эскиз зураг (Улаанбаатар хотын Ерөнхий архитекторын батласан)
- Иргэн, аж ахуй нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл (Барилгын мэдээлэл, хэмжээ $м^3$, зориулалт, халаалтын системийн болон бусад хэрэглээний дулааны ачааллын хэмжээ, тооцоо (Гкал/ц -аар)-г эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлж тусгасан байх
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Тодруулах хуудас
- Газар өмчлөх, эзэмших, ашиглах гэрчилгээ, кадастрын хамт (Нийслэл, дүүргийн засаг даргын захирамж)
- Шугам, тоноглол эзэмшигчийн тодорхойлолт, зөвшөөрөл
- Баригдсан барилга бол үл хөдлөх, эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ.

2.4. Шинээр техникийн нөхцөл авах барилга обьектын эзлэхүүн нь нийтдээ 3600 $м^3$ -ээс доош байх, эсвэл дулааны ачаалал нь 0.075 Гкал/ц-аас бага байх тохиолдолд, "Архитектур төлөвлөлтийн даалгавар, "Батлагдсан эскиз зураг" зэргийг "Улаанбаатар хотын Ерөнхий архитектороор батлуулах"-гүй байж болно.

2.5. Иргэн, хуулийн этгээдэд олгосон техникийн нөхцөл нь тухайн зөвшөөрөл хүссэн барилга обьектыг төвлөрсөн дулаан хангамжид холбох үндэслэл болно.

2.6. Шинээр олгогдсон техникийн нөхцөл нь тухайн хугацаанаас хойш хоёр жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд энэ хугацаанд багтаж иргэн, хуулийн этгээд нь тухайн барилга обьектоо бүрэн ашиглалтанд оруулж, улсын комиссын акт гарсан тохиолдолд олгогдсон техникийн нөхцөлийн шаардлага бүрэн биелэгдсэнд тооцож, баримтыг обьектын архивд хадгална.

2.7. Харин техникийн нөхцөлийн хүчинтэй байх хугацаанд тухайн барилга обьектоо бүрэн ашиглалтанд оруулаагүй тохиолдолд уг техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгуулах хүсэлтээ техникийн нөхцөлийн цахим системд хандах бөгөөд баталгаажуулсан гадна шугам сүлжээ, дулаан механикийн зураг төслийн хамт ирүүлнэ.

Гурав. Зөвлөлийн эрх, үүрэг.

3.1. Эрчим хүчний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, норм, дүрмийн заалтын дагуу дулааны техникийн нөхцөл олгох, эс олгох асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй.
3.2. Уг зөвлөл нь энэхүү үндсэн үүргээ биелүүлэх үйл ажиллагааныхаа хүрээнд бие даасан, хараат бус субъект байна.
3.3. Техникийн нөхцөл олгохтой холбогдсон баримт бичиг, магадлагааг холбогдох иргэн, хуулийн этгээдээс гаргуулан авах эрхтэй.
3.4. Хууль тогтоомж, норм, дүрэм, стандартын шаардлага, тухайн объектод олгосон техникийн нөхцөлийн шаардлагыг зөрчсөн зураг төсөл, дутуу буюу чанаргүй гүйцэтгэсэн барилга байгууламж, шугам сүлжээний угсралт, шинэчлэл, засварын ажил илэрсэн бол зөрчил, дутагдлыг арилгуулах үүрэгтэй. (Дээрхтэй холбогдох үзлэг хяналтыг ДШСА /Дулааны шугам сүлжээний алба/ гүйцэтгэнэ.)
3.5. **"ДУЛААН ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ ХОЛБОЛТЫН ЖУРАМ"-ын 2 дугаар заалтыг үндэслэн тус** зөвлөл нь иргэн, хуулийн этгээдийн баримт бичгийг хүлээн авснаас

хойш 14 хоногийн дотор хүсэлт гаргагчийн хамт дулаан дамжуулах, түгээх сүлжээнд холбогдох техникийн боломж, хамгаалалтын зурвас зөрчсөн эсэхийг газар дээр нь тодорхойлж, хүчин чадал, сүлжээний гидравлик тооцоо, шаардлагатай өргөтгөл, шинэчлэлийн ажлуудыг хамруулан, холбогдох зардлын тооцоог хийж судалсан байх ба энэ тухай баримт мэдээллийг ДШСА-наас танилцуулсныг үндэслэн эцсийн шийдвэр гаргана.

Дөрөв. Зөвлөлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн тус бүрийн хариуцах ажлын чиглэл.

4.1. Иргэн, хуулийн этгээдээс дулааны техникийн нөхцөл авах талаар цахим системд оруулсан хүсэлтийг шийдвэрлэх ажлыг бүрэн хэмжээнд энэхүү зөвлөл хариуцан гүйцэтгэнэ.
4.2. Уг зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй бөгөөд гишүүд тус бүрийн хариуцах ажлын чиглэл нь дараах байдалтай байна. Үүнд:

№	Зөвлөлийн бүрэлдэхүүн	Компанийн албан тушаал	Ажлын хариуцах чиглэл
1	Зөвлөлийн дарга	Ерөнхий инженер	а/. Шаардлагатай цаг тухайд нь зөвлөлийг зарлан хуралдуулах. б/. Шинээр ирсэн хүсэлтүүдийг шийдвэрлэхэд төвлөрсөн дулаан хангамжийн техникийн бодлогод хэрхэн нөлөөлөхийг хянах. в/.Шинээр холбох техникийн нөхцөлтөй холбогдуулан эх үүсвэрийн болон дулаан хангамжийн системийн техник технологийн хүртээмж тал дээр хяналт хийх. г/. Тухайн техникийн нөхцөл олголтын боловсруулалтын үйл ажиллагааны оновчлолын тал дээр анхаарал хандуулах.
2	Нарийн бичгийн дарга	ДШСА-ны Горим, тохируулгын инженер	а/. Холбогдох цахим системийг хянаж, мэдээлэл ирсэн үед нь цаг алдахгүйгээр, газар дээр нь зохих хяналт хийж, шаардлагатай материал, бичиг баримтыг бүрдүүлэн цаг тухайд нь зөвлөлийг хуралдуулах санал өгөх. б/. Хурлын ирцийг цагт нь бүрдүүлэх. в/.Шаардлагатай хариуг цахим системд цаг тухайд нь оруулах. г/. Тухайн хурлын зохих шийдвэрийг цахим системд товлосон цаг хугацаанд нь суулгах, хурлын тэмдэглэлийг аливаа зөрчилгүй баталгаажуулах. д/. Энэхүү зөвлөлтэй холбогдох бүх баримт бичгийг бүртгэн, хавтасжуулж хадгалах, архивд шилжүүлэх. е/. Энэхүү зөвлөлийн аливаа шийдвэрт дулаан хангамжийн шугам сүлжээний гидравлик горим ажиллагаатай холбогдох мэдээллийг үнэн зөв тусгасан байх.
3	Гишүүн	ДШСА-ны дарга	а/. Холбогдох цахим системийг хянаж, мэдээлэл ирсэн үед нь цаг алдахгүйгээр, газар дээр нь зохих хяналт хийж цаг тухайд нь бичиг баримтыг боловсруулж, зөвлөлийн хуралд хэлэлцүүлэх. б/. Хэрэв хүсэлтийн дагуу техникийн нөхцөл олгох

			боломжгүй тохиолдолд энэ тухай гарын үсэг бүхий товч тайлбар бичгээр гаргаж, хурлын тэмдэглэлд хавсаргасан байх. в/.Шаардлагатай хариуг цахим системд оруулах явцыг хянах. г/. Тухайн хурлын зохих шийдвэрийг цахим системд оруулах, хурлын тэмдэглэлийг баталгаажуулахад хяналт хийх. д/. Энэхүү зөвлөлтэй холбогдох бүх баримт бичгийг бүртгэн, хавтасжуулж хадгалах асуудлыг давхар хариуцах. е/. Энэхүү зөвлөлийн аливаа шийдвэрт дулаан хангамжийн шугам сүлжээний гидравлик горим ажиллагаатай холбогдох мэдээллийг үнэн зөв тусгасан байх асуудлыг бүрэн хариуцах.
4	Гишүүн	Техник хяналт, төлөвлөлтийн инженер	а/. Холбогдох материал бичиг баримттай нарийвчлан танилцаж, цаг тухайд нь зөвлөлийн хуралд оролцох. б/. Хүсэлт гаргагчийн обьектын хамаарах дулааны тооцооллыг хянах, дулаан хангамжийн шугам сүлжээний гидравлик горим ажиллагаатай холбогдох мэдээллийг хянах. в/.Шинээр боловсруулсан дулаан техникийн нөхцөлийг заалт бүрээр нь хурлын шийдвэртэй нийцэж буйг тогтоон хянах.
5	Гишүүн	Эдийн засагч	а/. Холбогдох материал бичиг баримттай нарийвчлан танилцаж, цаг тухайд нь зөвлөлийн хуралд оролцох. б/. Шинээр холбогдох хэрэглэгчийг аль болох хурдан шийдвэрлэх талаар санаа тавих в/.Хүсэлт гаргасан хэдий ч дулааны техникийн нөхцөл авч чадаагүй хэрэглэгчдийн шалтгааныг тодруулж, өөрийн хэрэглэгч болгох гарц байгаа эсэхийг судалж тогтоох. г/. Иргэн, хуулийн этгээд нь, техникийн нөхцөл батлагдсан тохиолдолд суурь хураамж болон системийн холболтын хураамжийг “БНДС” ТӨХК-ийн зохих дансанд орсон тухай бүр дулаан техникийн нөхцөлийг нь олгох асуудлыг биечлэн хариуцах.
6	Гишүүн	Борлуулалтын ин-женер	а/. Холбогдох материал бичиг баримттай нарийвчлан танилцаж, цаг тухайд нь зөвлөлийн хуралд оролцох. б/. Шинээр холбогдох хэрэглэгчийг аль болох хурдан шийдвэрлэх талаар санаа тавих в/.Хүсэлт гаргасан хэдий ч дулааны техникийн нөхцөл авч чадаагүй хэрэглэгч (ААН)-дийн шалтгааныг тодруулж, өөрийн хэрэглэгч болгох гарц байгаа эсэхийг судалж тогтоох. г/. Зохих зөвшөөрөл авч буй хүсэлт гаргагч (хэрэв тухайн этгээдийн байрлалын орчмын, хуучин хэрэглэгчдийн дулаан хангамж доголдолтой нөхцөлд)-ийн обьектын дулаан хангамжийн шугам сүлжээний гидравлик горим ажиллагаатай

			холбогдох мэдээллийг хянах, энэ тухай санал оруулах.
7	Гишүүн	Борлуулалтын оператор	а/. Холбогдох материал бичиг баримттай нарийвчлан танилцаж, цаг тухайд нь зөвлөлийн хуралд оролцох. б/. Шинээр холбогдох хэрэглэгчийг аль болох хурдан шийдвэрлэх талаар санаа тавих в/.Хүсэлт гаргасан хэдий ч дулааны техникийн нөхцөл авч чадаагүй хэрэглэгч (Айл өрх)-дийн шалтгааныг тодруулж, өөрийн хэрэглэгч болгох гарц байгаа эсэхийг судалж тогтоох. г/. Зохих зөвшөөрөл авч буй хүсэлт гаргагч (хэрэв тухайн этгээдийн байрлалын орчмын, хуучин хэрэглэгчдийн дулаан хангамж доголдолтой нөхцөлд)-ийн обьектын дулаан хангамжийн шугам сүлжээний гидравлик горим ажиллагаатай холбогдох мэдээллийг хянах, энэ тухай санал оруулах.

Тав. Хурлын зохион байгуулалт

5.1. Зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг зөвлөлийн нарийн бичгийн дарга зохион байгуулна.
5.2. Зөвлөлийн нарийн бичгийн дарга техникийн нөхцөл хүссэн баримт бичгийн бүрдлийг хянан үзэж, зөвлөлийн даргад танилцуулж, шаардлага хангасан гэж үзвэл зөвлөлийн хуралд хэлэлцүүлэх мэдэгдлийг тараана.
5.3. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хурлыг зохион байгуулан гишүүдийн ирцийг бүрдүүлэх, хурлын тэмдэглэл хөтөлж баталгаажуулах, техникийн нөхцөлийг олгох зөвлөлийн акт үйлдэх ажлыг гүйцэтгэнэ.
5.4. Зөвлөлийн гишүүдийн дөрөвний гурав буюу 75 хувийн ирц бүрдсэн тохиолдолд хурлын үйл ажиллагаа эхэлнэ.
5.5. Зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй тохиолдолд комиссын хурал эхлэхээс 1 хоногийн өмнө зөвлөлийн даргад урьдчилан мэдэгдсэн байна.
5.6. Тухайн хурлаар хэлэлцүүлэх иргэн, хуулийн этгээдийн дулааны техникийн нөхцөл авах талаар, цахим системд оруулсан хүсэлтийг энэ зөвлөлийн бүрэлдэхүүнд багтаж буй ДШСА-ны дарга, ДШСА-ны Горим, тохируулгын инженер нар (цаашид “ДШСА-ны төлөөлөл” гэх) урьдчилан нарийвчлан танилцаж, “Төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм”, “Холболтын заавар”, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм” болон “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”-ын техникийн болон бусад холбогдох дүрэм, стандартын шаардлага хангасан эсэхийг болон энэ журмын 4.2-т заасан ДШСА-ны төлөөлөл нарын тус бүрийн хариуцах ажлын чиглэлийн дагуу, мөн энэ журмын 3.4 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлснээр гарсан дүгнэлтийг хүсэлт тус бүрээр нь зохих шийдвэрийн төслийн хамт боловсруулж, зөвлөлийн хуралд танилцуулна.
5.7. Хуралд оролцож буй зөвлөлийн гишүүд нь ДШСА-ны төлөөллөөс танилцуулж буй шинээр цахим системд бүртгэгдсэн иргэн болон хуулийн этгээдийн дулааны техникийн нөхцөл олгох талаарх шийдвэрийн төслийг сонсож, шаардлагатай гэж үзвэл 4.2-т заасан, зөвлөлийн гишүүд тус бүр өөрсдийн хариуцах ажлын чиглэлийн болон бусад холбогдох хууль, дүрэм журмын дагуу лавлагаа, тодруулга авна.

5.8. Зөвлөлийн хурлын явцад хэлэлцүүлсэн дулааны техникийн нөхцөл олгох талаарх шийдвэрийн төслийн танилцуулга сонсож, түүнтэй холбогдох лавлагаа, тодруулга авагдсаны дараа эцэслэн шийдвэрлэгдсэн дулааны техникийн нөхцөлийн төсөл нэг бүрийг дэмжих эсэх дэмжих асуудлаар хуралд оролцогч гишүүдийн санал хураах олонхийн саналаар шийдвэрлэнэ.

5.9. Зөвлөлийн гаргасан шийдвэрийг үндэслэн олгосон техникийн нөхцөлд болон тухайн хурлын тэмдэглэлд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гарын үсэг зурж албажуулах ба шинээр олгосон техникийн нөхцөлийг станцын Гүйцэтгэх захирлаар батлуулж, огноо, дугаарыг тодотгож, санхүүд шилжүүлэх, мөн заасан хугацаанд нь багтааж цахим системд зохих тэмдэглэлийг оруулна. Хэрэв зөвлөлийн хурлаар тухайн хүсэлтэд дулааны техникийн нөхцөл олгоогүй тохиолдолд энэ тухай хурлын тэмдэглэлд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гарын үсэг зурж албажуулж, мөн заасан хугацаанд нь багтааж цахим системд зохих тэмдэглэлийг оруулна. Журмын энэхүү 5.9 дэх заалтыг, хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн хэрэглээний үндсэн ачаалал нь 1.0Гкал/ц-аас бага тохиолдолд хэрэгжинэ.

5.9.1. Хэрэв хурлаар хэлэлцүүлэгдсэн, хүсэлт гаргагч иргэн, хуулийн этгээдийн хэрэглээний үндсэн ачаалал нь 1.0-5.0Гкал/ц хооронд байх тохиолдолд дулааны шугам сүлжээний горим ажиллагаанд нөлөөлөх, техник технологийн шинэчлэл хийх тухай бүр Эрчим хүчний яам (техникийн нөхцөл олгох ажлын хэсэг)-тай хамтран гаргах тул энэ тухай хурлын тэмдэглэл хөтлөгдөж баталгаажихаас гадна, заасан хугацаанд нь багтааж цахим системд зохих тэмдэглэл(өгөгдсөн загвар хуудас бөглөх)-ийг оруулна.

5.9.2. Хэрэв хурлаар хэлэлцүүлэгдсэн, хүсэлт гаргагч иргэн, хуулийн этгээдийн хэрэглээний үндсэн ачаалал нь 5.0 Гкал/ц-аас дээш бол Эрчим хүчний яам (техникийн нөхцөл олгох ажлын хэсэг)-ын хурлаар шийдвэрлэх тул заасан хугацаанд нь багтааж цахим системд зохих саналаа оруулж, энэ тухай хурлын тэмдэглэл мөн хөтлөгдөж баталгаажуулагдсан байх.

5.10. Энэ журмын 5.9; 5.9.1; 5.9.2-т заасан бүхий л бичиг баримтуудыг бэлдэх, албажуулах, батлуулах, шилжүүлэх, заасан хугацаанд нь багтааж цахим системд зохих баримт мэдээлэл оруулах, биет баримтуудын эх хувийг дугаарлан хавтаслаж хадгалах үүргийг зөвлөлийн ДШСА-ны төлөөлөл бүрэн хариуцна.

Зургаа. Техникийн нөхцөл олгохгүй байх тохиолдол.

6.1. Дараах тохиолдлуудад зөвлөл нь дулааны техникийн нөхцөл олгохгүй болно. Үүнд:

- Горим ажиллагааны хувьд илтэд хүндрэл үүсэхээр, дулаан механикийн тоног төхөөрөмжийн хүчин чадал хангалтгүй, дулаан хангамжийн ачаалал тулсан байршилд
- Геодезийн хувьд хэт өндөрлөг, дулааны магистраль шугамаас алслагдмал байршилд
- “Барилгын норм ба дүрэм”-ийн шаардлага хангаагүй, дулааны алдагдал ихтэй барилга, объект /зургийн дагуу хийгдээгүй, модон. . . гм. /
- Мөн бусад аливаа илтэд хүндэтгэн үзэх шалтгаануудын улмаас.

Долоо. Бусад зүйл.

7.1. Иргэн, хуулийн этгээд нь дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл батлагдсан тохиолдолд суурь хураамж болох 198000 /нэг зуун ерэн найман мянга/ төгрөг, системийн

холболтын хураамж болох 198000/нэг зуун ерэн найман мянга/ төгрөг, нийт 396000 /гурван зуун ерөн зургаан мянга/ төгрөгийг зохих дансанд төлсөн байна.

7.1.1. Иргэн, хуулийн этгээдийн техникийн нөхцөлд тусгасан, дулааны ачаалал нь 5 Гкал/ц хүртэл байх нөхцөлд дээрх хураамжуудыг "Багануурын дулааны станц" ТӨХК-ийн зохих дансанд тушаах зөвлөлийн гишүүн эдийн засагчид хураамжийг дансанд орсон тухайн бүр мэдэгдэж, техникийн нөхцөлийг гардаж авна.

7.1.2. Хэрэв иргэн, хуулийн этгээдийн техникийн нөхцөлд тусгасан, дулааны ачаалал нь 5 Гкал/ц-аас их байх тохиолдолд дээрх хураамжуудыг ЭХЯ-ны зохих дансанд тушааж улмаар тэндээс техникийн нөхцөл олгогдоно.

7.2. Энэхүү журмын 5.6-д заасны дагуу зөвлөлийн ДШСА-ны төлөөлөл нь шинээр цахим системд бүртгүүлсэн иргэд, хуулийн этгээдийн шинээр ирүүлсэн хүсэлтүүдэд боловсруулж гаргасан шийдвэр тус бүрийнхээ төслийн талаарх аливаа хариуцлагыг биечлэн бүрэн хариуцна.

7.3. Зөвлөлийн ДШСА-ны төлөөллөөс бусад гишүүд нь энэ журмын 4.2-т заасан өөрсдийн тус тусын заагдсан ажлын хариуцах чиглэлийн холбогдох асуудлаар зохих бүрэн хариуцлагыг хүлээнэ.

7.4. Зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүд нь хуралдааны үед, энэ журмын 4.2-т заасан өөрийн ажлын хариуцах чиглэлийн холбогдох мэдээллийг ДШСА-ны төлөөллүүдээс авах явцад, хэрэв зарим нэг эргэлзээтэй, зөрчилтэй асуудал гарсан гэж үзвэл, тухайн гишүүн асуудлыг газар дээр нь биечлэн хянах үүднээс тухайн хурлын үйл ажиллагааг түр зогсоох эрхтэй.

7.5. Хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд ДЭХ-ээр хангах техникийн нөхцөл олгохдоо, тухайн иргэн, хуулийн этгээдийн барьж байгуулах инженерийн байгууламж нь тохижуулсан зам, талбай, ногоон байгууламжийг нэвтрэн гарах бол тэдгээрийг нөхөн сэргээхэд гарах зардлыг бүрэн хариуцах заалтыг, мөн тухайн обьектыг холбоход халаалтын цогц төхөөрөмжийн хүчин чадал, салбар шугам сүлжээг зайлшгүй өргөтгөх шаардлага гарсан бол тэдгээрт гарах зардлыг тухайн иргэн, хуулийн этгээд бүрэн хариуцах асуудлыг тус тус техникийн нөхцлийн шаардлагад оруулж өгсөн байна.

7.6. Энэхүү журмыг гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.